

ШИНЭ ШАШНЫ ХӨДӨЛГӨӨНИЙГ СУДЛАХ АРГА ЗҮЙН ХОЁР ХАНДЛАГЫН ТУХАЙД

Жаргалын Алтайбаатар (Докторант)
Философийн хүрээлэн, ШУА

Түлхүүр үгс: Шинэ шашны хөдөлгөөн, шинэ шашин, калт, гаж урсгал, уламжлалт шашин, уламжлалт бус шашин

Товч утга: Орчин үеийн шашин судлалын салбарын нэгэн онцгой судлагдахуун бол шинэ шашны хөдөлгөөн юм. Шашин өөрчлөгдөж буй хэлбэр үү, эсвэл гажуудаж байгаагийн илрэл үү гэсэн асуултад хэрхэн хариулж байгаагаас энэ төрлийн шашныг хэрхэн судлах арга зүйн хандлага нь тодорно. Энэ өгүүлэлд уг шашныг судлах нийгэм, социологийн хандлага болон теологи, сэтгэл зүйн хандлагын тухай өгүүлэх бөгөөд арга зүйн аль хандлагыг судалгаанд баримтлах тухай судлаач саналаа дэвшүүлсэн болно.

Сүүлийн жил гаруйн хугацаанд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээг хэсэгтээ шуугиулсан “МҮҮН-ий хэрэг явдал” нь олны анхаарал, сэтгэлийн хөдөлгөөнийг эцэст нь тулгасан мэдээллийн, дижитал, цахим (хэрэв ингэж нэрлэж болдог бол) хөдөлгөөн өрнүүлсэний эцэст аливаа нийгмийн үзэгдэл идэвхитэй, оргил үеэ даваад уруудаж эхэлдэг зүй тогтолын дагуу намжих төлөвтөө нэгэнт оржээ.

Хэвлэл мэдээллийн гол сэдэв болоод байсан Мүүн нь шашин мөн, биш тухайн маргаан, Мүүний боловсролын систем дэх сөрөг үр дагавар бүхий нөлөөлөл, улс төрчдийн мүүнист хандлага гэх зэрэг сэдвээр өгүүлэл, сурвалжлага, ярилцлага, нэвтрүүлэг олон нийтийн хүртээл болсон нь нэг талаас шашны гаж урсгал (калт)-ыг эсэргүүцэгчдийн армийг (анти-калист болон каунтер-калист хандлага)¹ бий болгож, харийн гэгдэх боловч өөриймсөөд эхэлчихсэн шашин шүтлэгийн бусад төлөөлөгчид (шашны цөөнх гэхэд хилсдэхгүй болов уу) нийгмийн сэтгэл зүйн хатуу ширүүн уур амьсгалаас айж болгоомжлох, нөгөө талаас буддын болон бөөгийн шашин шүтэгчдээс бусдыг нь хавчиж гадуурхах нөхцөл бараг бүрдчих дөхлөө.


Харийн шашин шүтлэгээс болгоомжлох, уламжлалт бус хандлага, нийгэмд танил бус үзэгдлээс жийрхэх нь ямар ч нийгэмд байдаг, үндэсний аюулгүй байдлын хувьд эрүүл үзэгдэл гэж хэлж болох боловч ул суурьтай, үндэслэлтэй, баримт нотолгоотой, шинжлэх ухаанч мэдлэг, мэдээлэлд тулгуурлаж асуудалд олон талаас нь эрүүл ухаанаар хандах нь цөөхөн хүн амтай Монгол Улсын хувьд юу юунаас илүү чухал юм.

Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд иргэдийн шашин шүтлэг, итгэл бишрэлийн төлөв байдлыг судалсан хэд хэдэн судалгааны үр дүнгээс үзэхэд Монголд өнөөдөр *үүсэл гарал, шинж чанар, агуулгаараа нэлээд ялгаатай, өөр өөр төрөл хэлбэрийн шашин шүтлэгийн илрэлүүд зэрэгцэн оршиж байгааг манай шашин судлаачид*² санал нэгтэй хүлээн зөвшөөрдөг. Эдгээрийг төстэй шинжээр нь бүлэглэж үзвэл дараах үндсэн таван бүлэгт хуваагдаж байна.

¹ *Анти-калт (anti-cult) нь гол төлөв судлаачид, калтад итгэгчдийн гэр бүл, асран хамгаалагчид зэрэг калтыг эсэргүүцэгчдийн санаачилгаар өрнөдөг нийгмийн шинжтэй хөдөлгөөн бол каунтер-калт (counter-cult) хөдөлгөөн нь христийн шашны теологийн үүднээс калтын сургааль номлолыг буруушаах, няцаахад чиглэдэг ажээ (Ж.А.).

² Цэдэндамба С., Монгол дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе). УБ., 2003; Гантуяа М., Орчин үеийн монголчуудын шашин шүтлэгийн байдал. – “Дэлхийн шашин шүтлэгийн чиг хандлага ба Монголын шашин судлал” олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, Монгол Улсын Их Сургууль, Монголын шашин судлаачдын нийгэмлэг, Улаанбаатар, 2014.01.16; Гантуяа М., Өнөөгийн монголчуудын шашин шүтлэгийн төлөв байдал, чиг хандлага //Философи, шашин судлал. №17(434), 2015; Пүрэвсүрэн Ц., Ховд аймаг дахь шашны өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага //Философи, шашин судлал. №308(51), 2009 г.м.

Зураг 1. Монгол дахь шашнууд



Энэ таван бүлгээс эхний дөрвийн талаар бид тодорхой хэмжээгээр мэдэх боловч тав дахь бүлэгт багтаж буй шашин шүтлэгийн төрөл, хэлбэрүүдийн талаарх судалгаа эхлэл шатандаа байгааг дурдах нь зүйтэй. Чухамдаа энэ бүлэг шашнуудын дотор л Мүүний шашин багтаж байгаа билээ.

Сүүлийн үед эдгээр шашин шүтлэгийг зарим тохиолдолд “шашин биш гаж урсгал”, “калт” (cult) гэж үзэх хандлага олон нийтийн дунд түгээмэл ажиглагдах боллоо. Гэвч орчин үеийн шашин судлалд эдгээрийг бүхэлд нь “шинэ шашны хөдөлгөөн” гэсэн нийтлэг нэршлээр нэрлэж судалсаар багагүй хугацаа өнгөрчээ. Тэгвэл эндээс чухам аль нь зөв нэршил вэ, үнэхээр эдгээр шашин нийгмээс гажууд, бусдаас гажууд юм уу, аль эсвэл нийгмээ дагаад шашин өөрчлөгдөж буй хэлбэр үү зэрэг нэг талаас танин мэдэхүйн шинжтэй, нөгөө талаас арга зүйн чанартай асуултууд урган гарч байна.

Энэ нь дээрх шашнуудын талаарх судлаачдын өөр хоорондоо ялгаатай арга зүйн хоёр хандлага, үзэл баримтлал, байр суурьтай холбоотой юм. Үүний нэг дэх нь, нийгмийн тогтсон хэв маяг, зан заншил, уламжлалаас өөр хандлагыг бий болгож, элсэгчдээ тархи угаах, ховсдох аргаар татаж, нийгмээс тусгаарладаг тул “шашны гаж буруу урсгал” буюу “калт” гэж үзэх шашны теологи, психологийн хандлага, хоёр дахь нь, нийгмийн өөрчлөлтөөс үүдэн уламжлалт, тогтсон үзэл сургаал, хандлага өөрчлөгдөж байгаа үйл явц, үзэгдэл гэж үзэх нийгэм, социологийн хандлага юм.

Калт буюу гаж урсгал гэж үзэх теологи, психологийн хандлага³

³ □ Калт (cult – eng, культ – рус.) гэх нэр томъёо нь гарвалын хувьд “мөргөл, шүтээн” гэсэн утга бүхий франц (culte), латин

Цаг хугацааны хувьд залуу, үзэл онолын хувьд шинэлэг, нийгмийн байр суурийн хувьд төдийлөн батжиж чадаагүй байхаас гадна байгууллагын хувьд “үүсэл, төлөвшилийн” шатандаа байх нь шинэ шашин, шинэ урсгал чиглэлийн нийтлэг шинж ажээ. Шинээр үүсч бий болсон шашны урсгал чиглэл, хөдөлгөөнүүд нь шашны байгууллагын энгийн хэлбэрүүд болох сект (бүлэглэл), калт (явцуу бүлэглэл, тахин шүтлэг)-ийн хэлбэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлдэг⁴ тул эдгээр шашнуудыг анхааран судалж эхэлсэн ХХ зууны эхний хагаст зарим шашин судлаачид “калт” гэсэн нэр томъёог хэрэглэх болжээ.⁵

1940-өөд оноос тухайн үед өрнө дахинд зонхилж байсан уламжлалт шашин болох христийн шашны судлаачид болон теологичдийн зүгээс өөрсдийн үзэл баримтлал, сургаал номлолд шүүмжлэлтэй хандсан, эсвэл шинэлэг үзэл санаа бүхий шашны урсгал, шинэ шүтлэг бүрийг бүхэлд нь хавтгайруулан “калт” гэж үзэн⁶ энэ нэр

(cultus) үгнээс гаралтай. Энэ нэр томъёог манай судлаачид монгол хэлнээ “шашны бүлэг”, “явцуу бүлэг”, “туйлширсан бүлэглэл”, “тахин шүтлэг” гэж орчуулан хэрэглэхээс гадна сүүлийн үед зарим судлаачид “гаж урсгал” гэж орчуулан судалгааны бүтээлдээ хэрэглэх болсон. Энэ удаад уг нэр томъёог хэрхэн орчуулан хэрэглэхээс өгүүллийн үзэл баримтлал, хандлага илрэх тул бид англи галигийг баримтлан орчуулалгүй хэрэглэв.

⁴ “Энд Эрнст Трелья, Милтон Юнгер нарын шашны байгууллагын “church-sect” ангиллын үүднээс авч үзсэн болно. Сект бол уламжлалт шашны байгууллагын эсрэг сөрөн зогсож, тэдний үйл ажиллагааг шүүмжлэн, өөрсдийн шашны шинэ үзэл сургаал, баримтлалыг бий болгон, нийгмийн оюун санааны амьдралд нөлөөлөхийг оролддог бол культ нь шашны тахил шүтлэгийн зан үйл нь зөрчилдсөний улмаас ноёрхогч шашин болоод нийгмээс салан тусгаарлаж, нийгмийн шинэ дэг ёс, шинэ хэм хэмжээг гаргаж ирэхийг зорьдог ажээ. Troeltsch, Ernst. “The Social Teachings of the Christian Church”, London, Macmillan, 1931, Yinger, J. Milton. “The Scientific Study of Religion”, London, 1970 зэрэг бүтээлүүдээс нь дэлгэрүүлэн үзнэ үү.

⁵ The Oxford Handbook of New Religious Movements, Oxford University Press, 2008, p.17

⁶ Introvigne, Massimo “The Future of Religion and the Future of New Religions”. http://www.cesnur.org/2001/mi_june03.htm. (June 15, 2001), Эшлэсэн 2017-01-16

томъёог шашны байгууллагын нэг хэлбэр гэхээсээ илүүтэйгээр “ноёлогч шашинтай сөргөлдөгч, тэрслэгчид” гэсэн агуулгаар авч үзэх явдал давамгайлах хандлагатай болсон байна. Тэд, Библийн үндсэн зарчимаас гажсан бүх урсгалыг “калт” гэж үздэг ажээ⁷.

Теологи, психологийн хандлагыг баримтлагчид үндсэндээ дараах хоёр бүлгээс бүрдэж байна. Үүнд:

1. Зонхилогч шашны уламжлалт номлол сургаалаас гажсан тул калт буюу “гаж урсгал” гэж үзэх христийн шашны теологийн хандлага нь гол төлөв Евангелистүүдээс бүрдсэн “каунтер-калт” (*counter-cult*) хөдөлгөөний хэлбэрээр илэрч байна.
2. Сүсэгтнийхээ сэтгэл зүй, зан төлөвт нөлөөлөх замаар нийгмийн тогтсон хэм хэмжээ, сэтгэлгээнд сөрөг нөлөө үзүүлдэг шашны гаж буруу урсгалууд гэж үзэх психиологичид голдуу судлаачдын үзэл баримтлал нь “анти-калт” (*anti-cult*) хөдөлгөөний үзэл санааны суурь болж байна.

Теологийн хандлагыг баримтлагчид “калт” хэмээх нэр томъёо нь утгат чанараа одоо ч алдаагүй бөгөөд калтийг “Библи дэх христийн шашны үндсэн номлолыг үргэлж үгүйсгэдэг, калтын нэр хүнд бүхий удирдагч, хувь хүний ертөнцийг үзэх үзэлд суурилсан итгэл үнэмшил бүхий бүлэг хүмүүс” гэж тодорхойлдог⁸.

Теологич, христийн шашны каунтер-калт хөдөлгөөний төлөөлөгч Волтер Мартин (1928-1989) христийн шашны нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн уламжлалт номлол сургаалиас өөрөөр буюу хувь хүний үзэл бодол, итгэл үнэмшилээр Библийг тайлбарладаг нь калтын үндсэн онцлог гээд Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм (Мормон), Христийн Шинжлэх ухаан, Иовын гэрчүүд, Юнитариан юниверсалистүүд зэргийг жишээ болгон дурджээ⁹.

Теологийн хандлага нь нэг талаар Библид үл нийцэх байдлыг калт гэж үзэх гол шалгуур болгон авч үзсэн нь зөвхөн Христийн шашны нэр холбогдсон урсгал, чиглэлүүдэд

хамаатай мэт боловч, нөгөө талаар Библийн бус номлолтой шашны бусад урсгалуудыг ч калт гэж үзэх үндэслэл бүхий санааг мөн дэвшүүлж байгаа юм.

Калт бол нийтийн соёл дахь шашны норматив илэрхийлэл болж хүлээн зөвшөөрөгдсөн итгэл үнэмшил, зан үйлээс илт ялгаатай шашны аливаа бүлэглэл¹⁰ гэж дээрхтэй төстэй санааг Чарльз Брэйдэн (теологич, методист, 1887-1970) дэвшүүлсэнээр нийгэм дэх уламжлалт болон уламжлалт бус шашин шүтлэгийн харьцаа, зааг ялгааг тодорхойлжээ.

Шашны психологийн зарим судлаачид уг шашнуудын итгэгчдээ татах, шашиндаа оруулахдаа “ятган үнэмшүүлэх (*brainwashing*)”, “оюун ухааныг удирдах (*mind control*)”, “ховсдох” зэрэг арга техникийг түлхүү хэрэглэдэг гэж буруушаан нийгмээс гажууд, ёсноос гажууд гэж үздэг нь орчин үеийн анти-калт (калтийн эсрэг, гаж урсгалын эсрэг) хөдөлгөөн үүсэн бүрэлдэхэд чухал нөлөө үзүүлсэн байдаг¹¹.

Ялангуяа, 1978 онд Гинуана дахь “Хүмүүсийн сүм” шашны байгууллагын үүсгэн байгуулсан Жонестаун сууринд тус шашны байгууллагын 900 гаруй гишүүн нэгэн зэрэг амиа хорлосон үйл явдал нь тухайн үед нийгэмд төдийлөн танигдаагүй байсан шашны олон янзын урсгал чиглэлүүд, тэр дундаа шинээр бий болж эхэлсэн шашны урсгалуудыг нарийвчлан судлах, тэдний нийгэм, бүлэг, хувь хүмүүст үзүүлэх сөрөг нөлөө, хор хөнөөл бүхий үр дагавараас урдчилан сэргийлэх хэрэгцээ, шаардлагыг бий болгожээ.

Ийнхүү өрнө дахины нийгэм, оюун санааны амьдралд эрчимтэй ажиглагдах болсон шашны өөрчлөлт, шинэ шүтлэгийн хэлбэр, хэв маяг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шашин судлаачдын анхаарлыг татаж эхэлсэн бөгөөд энэ төрлийн шашин шүтлэгийг судлах теологийн бус хандлага энэ үеэс эхтэй.

Калифорнийн их сургуулийн профессор, психологич Маргарет Зингер (1921-2003) калтын гишүүн байсан 3000 гаруй итгэгчдийн кейст хийсэн шинжилгээ, тархи угаах буюу шашны ятган үнэмшүүлэх арга технологийн

⁷ Christian Research Institute. “What is a religious cult?”. <http://www.equip.org/perspectives/what-is-a-religious-cult>. Эшлэсэн 2017-01-16

⁸ McDowell, Josh and Stewart, Don “The Deceivers: What Cults Believe; How They Lure Followers”. Amersham, Scripture Press., 1992

⁹ Martin, Walter R. “The Kingdom of the Cults”. Bethany Fellowship Inc., Publishers, Minneapolis, Minnesota. 1985

¹⁰ Larson, Bob. “Larson’s New Book of Cults”. Wheaton, Illinois, Tyndale House. 1982, p.14

¹¹ Fox, Judith. “New religious movements” in “Routledge Companion to the Study of Religions”. Ed. John Hinnels. Routledge. London, 2005, p. 325

талаарх олон жилийн судалгаанд үндэслэн калт бол нийгмийн болон хувь хүний сэтгэл зүйд хортой нөлөө үзүүлдэг үзэгдэл бөгөөд калтад итгэж байсан (калтаас гарсан) хүмүүст сэтгэл зүйн дараах сөрөг шинжүүд илэрдэг гэж үзжээ. Үүнд:

- Итгэл үнэмшилээ алдсан, утга учиргүй байдлын мэдрэмж бүхий сэтгэл гутралд автах.

- Найз нөхөд, тойрон хүрээлэгсэд, үзэл бодол нэгтнүүдээс холдсон ганцаардлын мэдрэмж төрөх.

- Тогтсон хуваарь, цагийн менежмент, дэг ёс, журмын дагуу амьдарч байсан тул шийдэмгий бус байдал илрэх.

- Зарим калтууд итгэгчиддээ шашны номлол, сургаалийг ховсдох, сэтгэлзүйд тогтмол нөлөөлөх (унтаж байхдаа аудио бичлэг сонсох, анхаарал төвлөрсөн нийтийн мөргөлийн дуу, тоглоом тоглох, хагас унтаа байдалд залбирал, тарни унших, бясалгах гэх мэт) замаар хүргэдэгээс калтаас гарсан хүмүүсийн дунд стресстэх, үзэл санаа, сэдэл, мэдрэмжийн зөрчилд орох, зарим тохиолдолд танил үг, сургааль, орчин бүрдэхэд калтад байсан үеийнх нь мэдрэмж сэргэх, транс байдалд орох зэргээр илэрдэг.

- Калтаас гарсан зарим итгэгчид калтын үзэл сургааль, номлолоос бүрэн ангижраагүй байдгаас хийсэн сонголтоосоо үүдэн тэнгэр, бурханы гэсгээлээс айх, шийтгэлээс айх, сонголтондоо эргэлзэх хандлага илэрдэг.

- Калтаас гарсан итгэгчид, тэднийг буцаад итгэгч болчих вий гэсэн найз нөхөд, гэр бүлийн байнгын ажиглалтад байдаг нь тэднийг сэтгэл зүйн дарамтад оруулдаг гэх мэт¹².

Теологи, психологийн хандлагыг баримтлагчид, калт нь нийгэмд ихэвчлэн хор хөнөөл учруулдаг^{13*} бөгөөд дараах хэд хэдэн шинжийг агуулдаг гэж үзжээ. Үүнд:

- Калт нь нийгмээс тусгаарлагдаж нууцлагдсан байдалтай үйл ажиллагаа явуулдаг;

¹² Singer, Margaret Thaler. "Coming out of the Cults" in Psychology Today. 1979. Resource: <http://www.cultfaq.org/coming-out-of-the-cults.html>

¹³ * Теологи, психологийн хандлагыг баримтлагч зарим судлаачид культ бол зөвхөн "хөнөөлт (destructive)" шинжийг агуулна гэж үздэг. Тухайлбал, Robinson: гишүүдийнх нь нас барах шалтгаан нь итгэл үнэмшил нь болдог (Robinson, B.A.) "Doomsday, destructive religious cults". Ontario Consultants

- Калт нь шүтэн бишрэгчдээ хууран мэхлэх замаар элсүүлдэг, гишүүнчлэл нь албадлагын шинжтэй;

- Калт нь авторитар, харизматик удирдагчтай;

- Сургаал номлолоо ятган үнэмшүүлэх (*brainwashing*) замаар түгээдэг;

- Нийтээр (коммун маягаар) амьдарч, хөдөлмөрлөх;

- Нийгэмдээ үл хүлээн зөвшөөрөгдсөн байдалтай байх зэрэг болно¹⁴.

Калт нь хүн хулгайлах, сэтгэл зүйд нөлөөлөх, айлган сүрдүүлэх, бэлгийн хүчирхийлэл, масс амиа хорлолт зэрэг гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийн орчин, шалтгаан, нөхцөл нь болдог гэж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн зүгээс буруутгагддаг боловч баримтаар нотлогдсон тохиолдол нь энэ төрлийн шашны байгууллагуудын дунд маш бага хэмжээг эзэлдэг¹⁵ ажээ.

Ийнхүү шинээр үүсч бий болсон шашны урсгал чиглэлүүдийг зонхилгогч шашны номлол болон нийгэм, соёлын уламжлалт хандлагад үл нийцдэг, үйл ажиллагаа, зохион

on Religious Tolerance, 2007); Michael Langone: итгэгчид, гишүүдийнхээ физиологи болон сэтгэлзүйд ноцтой хохирол учруулах (Turner, Francis J.; Arnold Shanon Bloch, Ron Shor. "Differential Diagnosis & Treatment in Social Work" (4th ed.). Free Press. 1995. pp. 1146: Chapter 105: "From Consultation to Therapy in Group Work with Parents of Cultists".) John Gordon Clark: засаглалын тоталитар (дарангуйллын) тогтолцоо, бизнес, ашгийн сонирхолтой байх (Clark, M.D., John Gordon. "The Effects of Religious Cults on the Health and Welfare of Their Converts". Congressional Record. United States Congress. 1977); Kaslow ба Sussman нар: зан төлөвийн болон хувийн шинж чанарыг өөрчлөх, бие хүний айдентитийг үгүй хийх, тогтсон уламжлалыг үгүй хийх, гэр бүлээс нь тусгаарлах, нийгмийн амьдралаас таслагдах, калтын удирдагчид үг дуугүй захирагдах, оюун санааг удирдах (Kaslow, Florence Whiteman; Marvin B. Sussman. "Cults and the Family". Haworth Press. 1982. p. 34.) гэх мэт.

¹⁴ MacKenzie, U. and Morrison, B. "New Religious Movements in Britain Today: A Resource Paper from CYFA". London, Church Youth Fellowships Association, 1982; Cowan, Douglas E. "Bearing False Witness? An Introduction to the Christian Countercult". Westport, CT: Praeger. 2003; Lewis, James R. The Oxford Handbook of New Religious Movements. Oxford University Press US. 2004; Richardson, James T. "Definitions of Cult: From Sociological-Technical to Popular-Negative". Review of Religious Research. 1993; Richardson, James T.; Introvigine, Massimo. "'Brainwashing' Theories in European Parliamentary and Administrative Reports on 'Cults' and 'Sects'". Journal for the Scientific Study of Religion. 2001. pp. 143-168; Stark, Rodney; Bainbridge, William Sims. "The Future of Religion: Secularization, Revival and Cult Formation". Berkeley, CA: University of California Press. 1987 зэргээс үзнэ үү.

¹⁵ Hill, Harvey, John Hickman and Joel McLendon. "Cults and Sects and Doomsday Groups, Oh My: Media Treatment of Religion on the Eve of the Millennium". Review of Religious Research. 43 (1), 2001, pp. 24-38; van Driel, Barend; J. Richardson. "Cult versus

байгуулалтын “хэвийн бус” шинжтэй гэж үзэн, шүүмжлэлт байр сууринаас авч үзэх нь теологи, психологийн хандлагын үндсэн агуулга юм.

Шинэ шашны хөдөлгөөнийг судлах нийгэм, социологийн хандлага

Ихэнхи судлаачид шинэ шашны хөдөлгөөний түүхийг XIX зууны дунд үед Европ, Хойд америк дахь спиритуализм болон эзотерицизмийн хүчээ авч эхэлсэн үеэс эхлүүлэн авч үздэг боловч дэлхийн II дайны дараах Японы нийгэмд шинто шашнаас салбарлан бий болсон олон арван шашны урсгалуудыг ангилан судлах хэрэгцээ шаардлагын улмаас тэдгээрийг “Японы шинэ шашны хөдөлгөөнүүд” нэрийн доор хамруулан авч үзэх болсон нь уг нэр томъёог шашин судлалд анх удаа хэрэглэсэн явдал байлаа.

Тухайн үед түгээмэл хэрэглэж байсан “калт” гэх нэршил нь “тэрс үзэлтэн, гажууд” гэсэн сөрөг утгыг илэрхийлэх болж улмаар нийгэмд энэ төрлийн шашны урсгалуудыг жигшин зэвүүцэх, шүтэгчид болон нийгмийн бүлгүүдийг гадуурхах, хяхаж хавчих, нийгмээсээ улам бүр тусгаарлагдаж хаагдмал болох нөхцлийг бүрдүүлэх болсон байна. Улмаар эдгээр бүлгүүд нь оршин буй нийгмийнхээ тогтсон хэв журмыг эсэргүүцэх, үзэн ядах, үзэл баримтлал, номлол сургаалиа нийгмийг цочроох хэмжээнд хүрэхүйц үйл ажиллагаа, үйлдлээр илэрхийлэх зэрэг ноцтой үр дагаварт хүргэх болжээ.

Иймээс, нэгд, тухайн зонхилгогч шашны үзэл санаа, шүтлэгийн шинэ чиг хандлагыг тодорхойлогч, цаг хугацааны хувьд залуу, байгууллагын хувьд төлөвшиж яваа шашны урсгал гэдэг мөн чанарыг нь товчлолгон гаргах; хоёрт; уламжлалт шашны үзэл баримтлал ба нийгэмтэй сөргөлдөгч байр суурь баримталдаг, гажуудсан, тэрсүүд гэж нийгэмд сөргөөр тогтсон ойлголтыг зүгшрүүлэх, гуравт, судлан буй объектод хөндлөнгийн, аль нэг талыг үл баримталсан шинжлэх ухаанч байр сууринаас хандан судлах зорилгоор энэ төрлийн шашны байгууллагыг “калт” гэж нэрлэхээс татгалзах саналыг Эйлин Баркер, Жеймс Т.Ричардсон, Тимоти Миллер, Катерин Веззингер нарын судлаачид гаргаж ирэх болжээ.¹⁶

Америкийн шашин судлалын институтыг (Institute for the Study of American Religion) үндэслэгч, захирал Жон Гордон Мелтон 1999 онд АНУ-д зохион байгуулагдсан Шинэ шашныг судлах төв (CESNUR)-ийн эрдэм шинжилгээний VII хуралд илтгэсэн илтгэлдээ¹⁷ “шинэ шашны хөдөлгөөн” гэсэн нэр томъёог албан ёсоор хэрэглэхийг санал болгосон нь өнөөдөр түгээмэл ашиглагдаж байна.

Дээрх шалтгааны улмаас өнөөдөр шашин судлаачид, шашны социологичид “калт” гэх нэршилээс татгалзан “шинэ шашны хөдөлгөөн” гэсэн нэр томъёог түлхүү хэрэглэж байгаа бөгөөд зарим судлаачид “альтернатив шашны хөдөлгөөн”¹⁸, “нэн шинэ шашин”¹⁹, “завсарын буюу шилжилтийн шашны хөдөлгөөн”²⁰ зэрэг нэр томъёог хэрэглэж байна.

Шинэшашныхөдөлгөөндямаршүтлэгийн хэлбэрүүд багтаах талаар судлаачид янз бүрийн байр суурийг баримталдаг. Тухайлбал, шинэ шашны хөдөлгөөнүүд үүсч бий болсон цаг хугацааны хувьд Их Британийн шашин судлаач, “Journal of Contemporary Religion” сэтгүүлийг үндэслэгч асан Питер Бернард Кларк (1940-2011) шинэ шашны хөдөлгөөний судалгаагаа 1945 оноос хойш буюу Дэлхийн II дайнаас хойш Их Британид бий болж үйл ажиллагаагаа эхэлсэн шашны урсгал чиглэлүүдэд гол төлөв чиглүүлж байсан²¹ бол Эйлин Баркер (шинэ шашны хөдөлгөөнийг судлах олон улсын сүлжээ байгууллага болох INFORM-ийг үндэслэгч, Британийн шашин судлаач) 1950-аад оноос хойш бий болсон шашны байгууллагуудыг шинэ шашны хөдөлгөөнд хамруулан судалж байна²².

Зарим судлаачид дэлхийн II дайны дараахан шинэ шашны хөдөлгөөнүүд бий болж эхэлсэн гэдэгтэй санал нэгддэг боловч 1960-1970-аад оны үеэс өнөөгийн жинхэнэ

CESNUR 99. http://www.cesnur.org/testi/bryn/br_melton.htm. (1999) Эшлэсэн 2017.01.20

¹⁷ Melton, J. Gordon., “The Rise of the Study of New Religions”. CESNUR 99. http://www.cesnur.org/testi/bryn/br_melton.htm. (1999) Эшлэсэн 2017.01.20

¹⁸ Miller, Timothy. “America’s alternative religions”. State University of New York. 1995

¹⁹ Ellwood, Robert S. “Introducing Religion: From Inside and Outside”. Edition 3. 1993. pp. 119-144

²⁰ Melton, J. Gordon., “The Rise of the Study of New Religions”. CESNUR 99. http://www.cesnur.org/testi/bryn/br_melton.htm. (1999) Эшлэсэн 2017.01 cap

²¹ Clarke, Peter, ed. “The New Evangelists: Recruitment, Methods and Aims of New Religious Movements”. London, Ethnographica. 1987. p. 5

²² Barker, Eileen. “New Religious Movements: A Practical Introduction”. London, HMSO. 1989. p. 9

sect: Categorization of new religions in American print media”. Sociological Analysis. 49 (2), 1988, pp. 171–183; Wright, Stewart A. “Media Coverage of Unconventional Religion: Any ‘Good News’ for Minority Faiths?”. Review of Religious Research, Vol. 39, No. 2. 39 (2), 1997, pp. 101–115

¹⁶ Melton, J. Gordon., “The Rise of the Study of New Religions”.

дүр төрхөө олсон гэж үздэг.²³

Түүнчлэн орчин үеийн гарал үүсэл бүхий шашны болоод гүн ухаан, оюун санааны бүлэг, нийгэмлэгүүдийг бүхэлд нь шинэ шашны хөдөлгөөн хэмээх нийтлэг нэр томъёогоор тэмдэглэн судлахаас гадна²⁴ эртний уламжлалтай томоохон шашнаас салбарлан гарсан шинэ урсгалуудыг ч хамруулан авч үзэх нь бий²⁵.

Үүсэн бий болсон түүхэн цаг үетэй нь холбон судлахаас гадна номлол сургаалийн уг сурвалж, нийгэмд хандаж буй хандлага, удирдлагын тогтолцоо зэрэг нийтлэг төстэй шинжид нь үндэслэн судалж байна. Шашин судлаачид өнөөг хүртэл бүртгэгдсэн шинэ шашны хөдөлгөөнүүдийг харьцуулан судалж дараах онцлог шинжүүдийг тодорхойлжээ. Үүнд:

- Шинэ шашны хөдөлгөөн нь номлол сургаалийн хувьд өөрсдийгөө эртний мартагдсан соёл иргэншил, уламжлалын улбааг хадгалсан гэх мөртлөө орчин үеийн соёл иргэншлийн нөхцөл байдалд нийцүүлэн сайжруулсан гэж тайлбарлах нь түгээмэл байдаг.
- Гол төлөв уламжлалт бус шашны хандлагатай, шашны уламжлалт урсгал чиглэлээс өөрсдийгөө ялган зааглахыг оролддог.
- Үзэл баримтлал, номлол сургааль нь гол төлөв бэхжээгүй, олон ургальч, мөн синкретик буюу янз бүрийн сургааль номлолын “холимог” байх нь нийтлэг. Номлол сургааль, сүсэг бишрэлийн тогтолцоо нь олон янзын эх үүсвэрээс бүрдсэн байх нь бий.
- Шинэ шашны хөдөлгөөн гол төлөв нэр хүнд бүхий удирдагчид, зарим тохиолдолд ер бусын эрдэм чадалтай, зөн билэгтэй хэмээн алдаршсан хэмжээлшгүй эрх мэдэл бүхий удирдагчийн оролцоотойгоор үүсэн байгуулагдсан байдаг.
- Ихэнхи шинэ шашны хөдөлгөөнүүд

явцуу хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг, нийгмээс тусгаарлагдсан байдаг.

- Зарим шинэ шашны хөдөлгөөн нь өөрсдийгөө орчин үеийн хийгээд олон ургальч үзэл санаа ба дэлхий нийтийн шинжлэх ухаанч хандлагын үр дүн гэж тайлбарладаг.

Шинэ шашны хөдөлгөөн үүсэн бүрэлдэхэд нийгмийн бүлэг, хамт олны гэхээсээ хувь хүмүүсийн оролцоо, байр суурь нэн чухал үүрэгтэй. Нэр хүнд бүхий буюу харизматик (*charismatic*) удирдагчид, тэднийг тойрон хүрээлэгч, дагагчдын харилцаа дээр уг шашны хөдөлгөөнүүд суурилах нь түгээмэл тул үүсэн бий болох, төлөвших үйл явцыг нь тэдний үйл ажиллагаатай нягт холбон тайлбарладаг²⁶. Тухайлбал:

- **Хөдөлгөөнийг үндэслэгч нь амьдралдаа тулгарч байсан сэтгэл зүйн хүнд хэцүү дарамт, стрессийн улмаас шинэ шашны урсгал бий болоход нөлөөлдөг.** Өөрөөр хэлбэл хөдөлгөөнийг үндэслэгч нь өөрөө сэтгэл зүйн ямар нэгэн эмгэг, эсвэл асуудалтай, түүнийгээ өөрөө эмчлэх, анагаах явцад тойрон хүрээлэгчидтэй болж шашны хөдөлгөөн болж төлөвшихөд нөлөөлдөг байна.
- Хөдөлгөөнийг үндэслэгчид нь шинэ бараа бүтээгдэхүүнийг зах зээл дээр гаргаж байгаа бизнес эрхлэгч мэт ажилладаг. Өөрөөр хэлбэл хөдөлгөөний үндэслэгчдийн ихэнхи нь шинэ шашны хөдөлгөөнийг үндэслэхээсээ өмнө өөр ямар нэгэн шашны урсгал, чиглэл, бүлэгт харьяалагддаг байсан бөгөөд тэд өмнөх шашныхаа үзэл санаа, туршлага дээр тулгуурлан илүү сайжруулсан өөрийн шашныг бий болгох, алдаршуулахыг зорьдог.
- Хөдөлгөөнийг үндэслэгч нь байгалийн ердийн үзэгдлийг ердийн бус хэмээн тайлбарлан, өөрийн авьяас билэг, чадварыг ертөнцийн бус, тэнгэр, бурханаас заяасан хэмээн итгүүлэх замаар өөрийн итгэгч, тойрон хүрээлэгчидтэй болсоноор шинэ шашны хөдөлгөөн үүсэж бий болдог.
- Нийгмээс болон шашны үндсэн чиглэлээс харилцаагаа таслан өөрсдийгөө тусгаарлан төвлөрч зөвхөн өөрсдийн

²³ Melton, J Gordon and Moore, Robert L. “The Cult Experience: Responding to the New Religious Pluralism”. New York, The Pilgrim Press.1982; Beckford, James. “Cult Controversies: The societal response to new religious movements”. London and New York, Tavistock Publications. 1985; Nelson, Geoffrey K. “Cults, New Religions and Religious Creativity”. London, Routledge and Kegan Paul. 1987

²⁴ Introigne, Massimo “The Future of Religion and the Future of New Religions”. http://www.cesnur.org/2001/mi_june03.htm. (June 15, 2001), Эшлэсэн 2017.01.16

²⁵ Chrystides, George D. “New Religious Movements - Some Problems Of Definition”. Diskus. 1994

²⁶ Giambalvo, Carol “Post-Cult Problems: An Exit Counselor’s Perspective” in Recovery from Cults: Help for Victims of Psychological and Spiritual Abuse, edited by Michael D. Langone. 1993. http://www.csj.org/infoserv_articles/giambalvo_carol_postcult_problems.htm. Эшлэсэн 2017.02.15

гишүүд болон шинээр элсэгчидээр л нийгмийн харилцаагаа хязгаарласнаар өөрсдийн гэсэн шинэ номлол, үзэл баримтлал, зан үйл бүхий шинэ шашны хөдөлгөөнийг бий болгодог. Өмнөх шалтгаануудаас ялгарах онцлог нь хөдөлгөөнийг үүсэхэд удирдагчийн үүрэг төдийлөн чухал бус бөгөөд бүлэг доторх гишүүдийн харилцаа улам бүр нягтрах, гадаад ертөнцөөс тусгаарлагдах үйл явц нь ийм үр дүнд хүргэдэг байна.

Шинэ шашны хөдөлгөөнийг хэлбэрийн хувьд олон янзаар ангилан судалж байна. Тухайлбал, социологич Родни Старк болон Уиллиам Бейнбриж нар шашны байгууллагын болон сүсэгтнүүдийн оролцооны түвшингээр нь дараах байдлаар ангилжээ. Үүнд:

- Зөвхөн номлол сургаалийг сонсох, зан үйлийг үйлдэх төдийгөөр хязгаарлагдсан, гишүүдийн оролцоо багатай шашны хөдөлгөөн.
- Хөдөлгөөний удирдлагын зүгээс сүсэгтнүүддээ байгууллага дотор эзэлж буй байр сууриас нь хамааруулан ялгавартай ханддаг шашны хөдөлгөөн. Удирдагч болон сүсэгтэн хоёрын харилцаа нь эмч ба өвчтөн, үйлчлэгч ба үйлчлүүлэгчийн харилцаатай төстэй.
- Бүх сүсэгтнүүдийнхээ сүсэг бишрэл, оюун санааны хэрэгцээг бүрэн дүүрэн хангахыг зорих боловч сүсэгтнүүдийнхээ элссэн цаг хугацаа болон итгэл үнэмшлийнх нь байдлаас нь хамааруулан ялгавартай ханддаг шашны хөдөлгөөн.²⁷

Социологич Рой Уоллис шинэ шашны хөдөлгөөнийг гадаад ертөнцтэй хэрхэн харилцдагаас нь хамааруулан ангилсан байдаг. Үүнд:

Нийгмээс тусгаарлагчид.

Тэд өнөөгийн нийгмийн тогтолцоо, дэг журам нь буруу бөгөөд эзэн тэнгэрийн номлол сургааль, төлөвлөгөөг илт мушгин гуйвуулсан, дэлхий ертөнц бол материалист хандлагатай, бүхэлдээ муу муухайн үүр гэж үздэг. Энэ хэлбэрт гол төлөв Христийн мянган жилийн хаанчлалын эхлэл буюу бурханы энэ ертөнцөд хийх шинэчлэлд итгэгч шашны хөдөлгөөнүүдийг багтаадаг бөгөөд тухайлбал, бидний хэлж заншсанаар

Мүүн буюу Эв нэгдлийн сүм (*the Unification Church*), Бурханы хүүхдүүд (*the Children of God*) болон Кришнагийн оюун санааны олон улсын нийгэмлэг буюу Хари Кришна хөдөлгөөн (*International Society of Krishna Consciousness* буюу "*Hare Krishnas*"), Брахма Кумирас (*Brahma Kumaris*) зэрэг шашны байгууллагуудыг нэрлэж болох юм.

Нийгэмд нийцтэй хөдөлгөөн. Тэд шашин, оюун санааны амьдралыг нийгмийнхээс тодорхой ялган заагладаг бөгөөд сүсэгтнүүдийнхээ нийгмийн амьдралд ач холбогдолтой болон хорттой нөлөө бараг үзүүлдэггүй. Тэд гадаад ертөнц, нийгмээс тусгаарлах эсвэл гадаад ертөнц, нийгмийг бүхэлд нь хүлээн зөвшөөрч, магтан дуулддаггүй боловч нийгэм болон гадаад ертөнцтэй зохицон оршин тогтнохыг эрмэлздэг.

Нийгмийг хүлээн зөвшөөрөгч хөдөлгөөн.

*Тэдэнд шашны хөдөлгөөнд байдаг тогтсон зан үйл, албан ёсны үзэл сургааль, ертөнцийг үзэх үзэл зэрэг элементүүд бараг байдаггүй. Тэд оршин тогтнож буй нийгмээ хүлээн зөвшөөрөх бөгөөд зөвхөн өөрт нуугдаж буй нуугдмал чанараа нээн илрүүлэхийг хүмүүст уриалдаг. Ийм хөдөлгөөний нэг жишээ бол Чинадад хүрэхүйн бясалгал (*Transcendental Meditation*) юм.²⁸*

Ийнхүү шинэ шашны хөдөлгөөнийг нийгэм, улс төр, эдийн засгийн даяарших үйл явц, шинжлэх ухаан, техник, технологийн өндөр хурдацтай хөгжил, хувь хүний эрхийн хийгээд эрх чөлөөний тухай үзэл санааны төлөвшил, чөлөөт сэтгэлгээ, олон ургальч байдлын түгээмэл чанар зэрэг хүчин зүйлсээс үүдэн нийгмийн оюун санааны хүрээнд гарч буй зайлшгүй өөрчлөлтийн нэг илрэл гэж үзэн нийгэм, соёлынх нь орчинд обьектив байр сууринаас судлах нь нийгэм, социологийн хандлагын үндсэн агуулга юм.

Шинэ шашны хөдөлгөөний талаарх монголын судлаачдын байр суурь

Монгол Улсад өрнөсөн нийгмийн оюун санааны хүрээнд гарсан олон өөрчлөлтийн нэг нь хүн амын шашин шүтлэг, сүсэг бишрэлийн өөрчлөлт байлаа. Итгэл бишрэлийн эрх чөлөө, оюун санааны олон ургальч үзэл, чөлөөт сонголтын үр дүнд Монгол улсад олон шашинт нийгэм бүрэлдэн бий боллоо. Энэ нь нэг талаас үндэсний уламжлалт шашин шүтлэг сэргэх, нөгөө талаас гаднаас шинэ шашин шүтлэг нэвтрэх хэлбэрээр илэрч

²⁷ Stark, Rodney; Bainbridge, William. "A Theory of Religion". Peter Lang Publishing. 1996. p. 155

²⁸ Saliba, John S.J. "Understanding new religious movements" second edition, Altamira press, 2003, pages 140-141, дам ишлэв.

байна.

Шинэ шашны урсгал чиглэлүүдийн талаар өдгөө шинжлэх ухааны ул үндэстэй, нарийн, тоймтой судалгаа Монголд хийгдээгүй байгаа нь нэг талаас нийгэмд янз бүрийн үзэл бодол, шүүмжлэл өрнөх, аль нэг шашны урсгал чиглэл, бүлгийг хэт үгүйсгэх, итгэн бишрэгчдийг нийгэмд гадуурхах, улмаар шашин хоорондын үл ойлголцол нийгмийн янз бүрийн бүлгүүдийн дунд бий болох хандлага ажиглагдаж байна. Нөгөө талаар гадны шашны бүлгүүд нь зөвхөн шашин шүтлэгийн хүрээнээс хальж улс төр, эдийн засгийн янз бүрийн ашиг сонирхол, зорилготой үйл ажиллагаа явуулах, ашгийн болон бусад чиглэлийн үйл ажиллагаанд нэр холбогдож, нийгэмд сөрөг үзэгдлийг бий болгож болзошгүй байдалтай байна. Иймд энэ талаар шинжлэх ухааны түвшинд тодорхой хэмжээний судалгаа, шинжилгээ хийх, олон нийтэд үндэслэлтэй мэдээлэл, мэдлэгийг түгээх зайлшгүй шаардлага бий болж байгаа юм.

Шинэ шашны хөдөлгөөн, тэдгээрийн талаарх дутуу дулимаг ойлголт нь эдгээр шашны урсгалууд нийгэмд бодитой аюул занал учруулж байна уу, эсвэл улс төр, цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн нийтийг хамарсан сэтгэл зүйн тоглолт уу гэдгийг ялгаж зааглахад төвөгтэй болгож байна.

Монголд шинэ шашны судалгаа нь онолын түвшинд эхлэл төдий байгаа боловч уламжлалт болон уламжлалт бус шашин, тэдгээрийн талаарх төрөөс баримтлах бодлого, шинэ шашны урсгал, хөдөлгөөнүүдийн ангилал, үйл ажиллагааны онцлог, хувь хүн, нийгэмд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг тодорхой хэмжээнд судалсан судлаачдын ажлын зарим үр дүн судалгааны эргэлтэд орж, нийтийн хүртээл болоод эхэлжээ.

Манай судлаачдын хувьд шинэ шашны хөдөлгөөнд уг өгүүлэлд дурдсан хоёр ялгаатай байр суурины аль алиных нь үүднээс хандан судлах байдал ажиглагдаж байна.

Шашин судлаач, профессор С.Цэдэндамба, XX, XIX зууны зааг үеэс эхэлсэн монголын нийгмийн оюун санааны амьдрал дахь шашны өөрчлөлтийг ажиглан судалж, шинэ нөхцөл дэх монголчуудын шашин шүтлэг, тэр дундаа уламжлалт ба уламжлалт бус шашин шүтлэгийн харилцааны асуудлыг хөндсөн нь өнөөдөр энэ чиглэлийн судалгааны үндсэн эх сурвалж болон ашиглагдаж байгаа юм²⁹.

²⁹ Цэдэндамба С., “Монгол дахь шашны нөхцөл байдал (XX-

Тэрээр шинэ шашны хөдөлгөөнийг Монголын нийгмийн оюун санааны хүрээний өөрчлөлтийн нэг үр дүн гээд эдгээр шашинд сүүлийн 25 жилийн хугацаанд буюу ардчилсан өөрчлөлтийн жилүүдэд Монголд шинээр дэлгэрсэн шашны урсгал, чиглэлүүдийг бүхэлд нь хамруулан авч үзсэн байна.

Ингэхдээ олон нийтийн зүгээс буддын болон бөө мөргөлийн уламжлалт шашин шүтлэгээс бусдыг “гадны шашин”, “харийн шашин” гэж үздэг хандлагын үүднээс тайлбарлавал христийн шашны католик, ортодокс, протестант шашны урсгал чиглэлүүд нь “уламжлалт бус шашин”, “шинэ шашин” гэсэн нэршил, ангилалд багтааж үзсэний дээр, сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Монголд бий болж төлөвшсөн уламжлалт бус төдийгүй уламжлалт шашны шинэчлэгдсэн хэлбэрийг ч энэ төрлийн шашинд хамаатуулан авч үзэж болох юм гэсэн санааг дэвшүүлжээ³⁰.

Судлаач Цэдэндамба, Монгол дахь шинэ шашны хөдөлгөөний үүсэн бүрэлдэх, дэлгэрэх үйл явцыг уламжлалт шашны хямралт байдал ба шинэ шашны эрэл хайгуул, нийгмийн өөрчлөлт ба модернизацийн нөлөө, шашнуудын “нүүдэл” ба даяаршлын нөлөө, шинэ шашны түрэлт ба дэлгэрэлт зэрэг нийгмийн нөхцөл шалтгаантай холбон тайлбарласнаараа асуудалд нийгэм, социологийн хандлагын үүднээс хандаж байгааг илтгэж байна.

Мөн судлаач С.Тайвансүрэн, Ц.Пүрэвсүрэн нар 1990-ээд оноос хойш Монголд дэлгэрсэн уламжлалт бус шашны хүрээнд шинэ шашны хөдөлгөөнүүдийг хамруулан авч үзсэн бөгөөд шинэ шашны хөдөлгөөн нь цаг хугацааны хувьд саяхнаас үүссэн, гол төлөв “гаднаас” орж ирж байгаа, эсвэл тухайн нийгмийн огцом өөрчлөлт буюу хямралт байдлын үр дагавар болон гарч ирж байгаа шүтлэгийн хэв маяг гэж үзжээ^{31 32}.

Судлаач Ц.Пүрэвсүрэн энэ төрлийн шашинд,

XXI зууны зааг үе)”. УБ., 2003; Цэдэндамба С., “Уламжлалт ба уламжлалт бус шашны харилцааны асуудал” // Төр сүм хийдийн харилцаа: орчин үе. Улаанбаатар, 1998

³⁰ Tsedendamba S., New Religious Movements in Modern Mongolia: Their Social Impacts and Issues”. “Religious Movements in a Globalized World: Korea, Asia, and Beyond” олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэл. CESNUR, БНСУ-ын Дайсүн Их Сургууль, 2016.07.5-10.

³¹ Тайвансүрэн С., “Монгол дахь шинэ шашнуудын номлол сургаал, үйл ажиллагаа”//Философи, шашин судлал. №308(51), 2009. хууд. 153-164

³² Пүрэвсүрэн Ц., “Монголын баруун бүс нутаг дахь шинэ шашны хөдөлгөөнүүд” //Философи, шашин судлал. №308(51), 2009. хууд. 291-304.

1. Нэн шинэ үед Монголд дэлгэрч буй христийн шашин, түүний төрөл, хэлбэрүүд,
2. Өөр бусад шашин шүтлэгийн илрэлүүдийг багтаан авч үзсэн бол
 1. Судлаач С.Тайвансүрэн,
1. Өрнийн уламжлалтай шинэ шашнууд (Мормон, Бахай, Баптизм, Адвентист г.м.)
2. Дорнын уламжлалтай шинэ шашнууд (Шри Чинмой, Ананда Марга, Рави шанкар г.м.) гэж авч үзжээ.

Ийнхүү шинэ шашны хөдөлгөөн нь нийгмийн өөрчлөлтийн үр дагавар, шашны хувьсан өөрчлөгдөж буйн илрэл гэж үзэх нийгэм, социологийн хандлагаас гадна нийгэмд хөнөөл бүхий шашны гаж урсгалууд гэж үзэх теологи, психологийн хандлагыг манай зарим судлаачид илэрхийлж байна. Тухайлбал, судлаач С.Дэмбэрэл, Ж.Пүрэвдорж нар энэ төрлийн шашны урсгал чиглэлүүд нь нийгмийн, ёс суртахууны, сэтгэлзүйн болон теологийн гажуудлыг агуулсан тул “гаж урсгал” гэж үзээд теологийн болон нийгэм-сэтгэл зүйн үүднээс илэрдэг гаж шинж тэмдэгүүдийг тодорхойлсон байдаг^{33 34*}. Эдгээр гаж шинж тэмдэгүүд нь:

1. Теологийн үүднээс бол Библийн үндсэн онол сургаалийг эсэргүүцдэг, Библийн бүрэн эрх мэдлийг үгүйсгэдэг, Библид ер бусын ба зөнч тайлбар хийдэг, Библийн ухагдахууныг бусад шашин, шинжлэх ухааны ойлголтуудтай хольдог.
2. Нийгэм-сэтгэл зүйн зүгээс бол хувь хүний эрхийг зөрчдөг, сэтгэлзүйн болон бие махбодийн, сүнсний дарамтад оруулдаг, өөрийн үзэл санаагаа илэрхийлэхийг хатуу хориглодог, бусдын бодол санааг бүрэн үгүйсгэдэг, үндсэн соёл, нийгмээс өөрсдийгөө салан тусгаарладаг, хууран мэхэлдэг, зөрчил тэмцлийг өдөөдөг, нийгмийн эсрэг турхирдаг зэрэг ажээ.

Арга зүйн энэхүү хоёр хандлага нь шинэ шашны хөдөлгөөнийг судлахдаа үзэл баримтлал, судлах арга, нийгэм, хувь хүнд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөлөл, үр дагаварын тухай төсөөллийн хувьд ялгаатай байдаг тул шашин судлаачид, ялангуяа шинэ

шашныг судлагчдын нэр томьёо хэрэглэх сэдэл, хандлага анхнаасаа хэрхэн тогтсоноос судалгааны үр дүн шууд хамаарна.

Өнөөдөр Монгол Улсын нийт хүн амын 60-аас доошгүй хувь нь шашин шүтэж, гадаадын болон дотоодын 700 гаруй сүм хийд, олон зуун сүм хийдийн бус шашны байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. 1990-ээд оны эхэн үетэй харьцуулахад шашны байгууллагын тоо 20 дахин ихсэж, насанд хүрсэн 3 монгол хүн тутмын 2 нь ямар нэгэн шашинд итгэж биширч байна. Шашны олон арван урсгал гадны янз бүрийн байгууллагын дэмжлэг, монголчуудын өөрсдийн итгэл үнэмшлээр дэлгэрч манай улс шашны эрх чөлөөг дээдэлсэн олон шашинт улс болжээ.

Шашны итгэл үнэмшил, сүсэг бишрэлийн олон янз байдал нь улам бүр хүрээгээ тэлж буй энэ нөхцөлд янз бүрийн шашин шүтлэгийн нийгэм, хувь хүнд үзүүлж буй нөлөөлөл, үр дагавар, түгэн дэлгэрч буй цаад учир шалтгааныг судлахдаа хатуу эсэргүүцсэн, буруушаасан байр суурь оновчтой арга хэрэгсэл болж чадахгүй.

Өөрөөр хэлбэл аль нэг шашин, тогтсон уламжлалын үүднээс, асуудалд зөвхөн сөрөг байр сууринаас ханддаг теологи, сэтгэлзүйн хандлагаас илүүтэйгээр эдгээр шашны үүсч, дэлгэрэх шалтгаан, үйл явц, үр нөлөө зэргийг объектив байр сууринаас авч үздэг нийгэм, социологийн хандлага нь бидэнд илүү тохиромжтой юм. Энэ нь дараах ач холбогдолтой. Үүнд:

Нэгд, орчин үеийн дэлхийн шашин судлалын хандлага, арга зүй, аргачлалын дэвшилтэй хөл нийлүүлэх боломж олгоно. Өнөөгийн шашин судлаачид асуудалд улам бүр объектив байр сууринаас ханддаг болсоор байгаа нь шашин шүтлэг, итгэл үнэмшилийн тухай үнэн бодит шинжлэх ухааны мэдлэг хуримтлагдах үндсэн нөхцөл болж байна. Энэ нөхцөлд өнөөдөр хүрээгээ улам бүр тэлсээр буй шинэ шашныг судлах нийгэм, социологийн хандлагаар асуудалд хандах нь энэ чиглэлийн судалгааны орчин үеийн ололт, арга зүй, аргачлалтай танилцах, суралцах, туршлага хуримтлуулах, дэлхийн шинжлэх ухаантай нэг хэлээр ярилцах боломжийг бидэнд олгох юм.

Хоёрт, шинэ шашны хөдөлгөөн, урсгал чиглэлүүдийг нийгмээс улам бүр тусгаарлагдах, нууцлагдахаас сэргийлж, тэдний тухай үргэлж мэдээлэлтэй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Шинэ шашны зарим

³³ Дэмбэрэл С., Пүрэвдорж Ж., “Христийн шашны гаж урсгалууд” //Философи, шашин судлал. №17(434), 2015. хууд. 149-156.

³⁴ * Шашин судлаачидаас гадна Монголын Евангелийн эвсэлээс христийн шашны номлол, сургаалыг гаж буруу тайлбарладаг шашны урсгал чиглэлүүдийн жагсаалтыг гаргасан байдаг.

хөдөлгөөнүүд нийгмийн эсэргүүцэлтэй тулгармагц нууц байдалд орох, оршин буй нийгэмдээ шүүмжлэлтэй хандах, улмаар оршин буй нийгмээ үзэн ядаж, хувьсган өөрчлөхийн тулд сөрөг нөлөөлөл, хөнөөл ихтэй үйл ажиллагаа явуулах зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг.

Гуравт, шүтэж бишрэх эрхийн асуудал нээлттэй болсоор буй орчин үеийн ертөнцөд иргэдийн шашин шүтлэгийн олон янз байдалд ялгаваргүй хандсанаар нийгмийн янз бүрийн бүлгүүдийн харилцан ойлголцолыг бэхжүүлэх, улмаар нийгмийн чухал ач холбогдолтой үйл хэрэгт санаа бодол, үйл хэргийг нь чиглүүлэх нөхцөл бүрдэх юм.

НОМЗҮЙ

1. Гантуяа М., Орчин үеийн монголчуудын шашин шүтлэгийн байдал. – “Дэлхийн шашин шүтлэгийн чиг хандлага ба Монголын шашин судлал” олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, Монгол Улсын Их Сургууль, Монголын шашин судлаачдын нийгэмлэг, Улаанбаатар, 2014.01.16
2. Гантуяа М., Өнөөгийн монголчуудын шашин шүтлэгийн төлөв байдал, чиг хандлага //Философи, шашин судлал. №17(434), 2015
3. Дэмбэрэл С., Пүрэвдорж Ж., “Христийн шашны гаж урсгалууд” //Философи, шашин судлал. №17(434), 2015. хууд. 149-156
4. Тайвансүрэн С., “Монгол дахь шинэ шашнуудын номлол сургаал, үйл ажиллагаа”//Философи, шашин судлал. №308(51), 2009. хууд. 153-164
5. Цэдэндамба С., “Уламжлалт ба уламжлалт бус шашны харилцааны асуудал” // Төр сүм хийдийн харилцаа: орчин үе. Улаанбаатар, 1998
6. Цэдэндамба С., Монгол дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе). УБ., 2003
7. Пүрэвсүрэн Ц., “Монголын баруун бүс нутаг дахь шинэ шашны хөдөлгөөнүүд” //Философи, шашин судлал. №308(51), 2009. хууд. 291-304
8. Пүрэвсүрэн Ц., Ховд аймаг дахь шашны өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага //Философи, шашин судлал. №308(51), 2009
9. Tsedendamba S., New Religious Movements in Modern Mongolia: Their Social Impacts and Issues”. “Religious Movements in a Globalized World: Korea, Asia, and Beyond” олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэл. CESNUR, БНСУ-ын Дайсүн Их Сургууль, 2016.07.5-10.
10. Barker, Eileen. “New Religious Movements: A Practical Introduction”. London, HMSO. 1989. p. 9
11. Beckford, James. “Cult Controversies: The societal response to new religious movements”. London and New York, Tavistock Publications. 1985
12. Clark, M.D., John Gordon. “The Effects of Religious Cults on the Health and Welfare of Their Converts”. Congressional Record. United States Congress. 1977
13. Cowan, Douglas E. “Bearing False Witness? An Introduction to the Christian Counter-cult”. Westport, CT: Praeger. 2003
14. Clarke, Peter, ed. “The New Evangelists: Recruitment, Methods and Aims of New Religious Movements”. London, Ethnographica. 1987. p. 5
15. Chryssides, George D. “New Religious Movements - Some Problems Of Definition”. Diskus. 1994
16. Christian Research Institute. “What is a religious cult?”. <http://www.equip.org/perspectives/what-is-a-religious-cult>. Эшлэсэн 2017-01-16
17. Ellwood, Robert S. “Introducing Religion: From Inside and Outside”. Edition 3. 1993. pp. 119-144
18. Fox, Judith. “New religious movements” in “Routledge Companion to the Study of Religions”. Ed. John Hinnels. Routledge. London, 2005, p. 325
19. Giambalvo, Carol “Post-Cult Problems: An Exit Counselor’s Perspective” in Recovery from Cults: Help for Victims of Psychological and Spiritual Abuse, edited by Michael D. Langone. 1993. http://www.csj.org/infoserv_articles/giambalvo_carol_postcult_

- problems.htm. ЭШЛЭСЭН 2017.02.15
20. Hill, Harvey, John Hickman and Joel McLendon. "Cults and Sects and Doomsday Groups, Oh My: Media Treatment of Religion on the Eve of the Millennium". Review of Religious Research. 43 (1), 2001, pp. 24–38
21. Introvigne, Massimo "The Future of Religion and the Future of New Religions". http://www.cesnur.org/2001/mi_june03.htm. (June 15, 2001), ЭШЛЭСЭН 2017-01-16
22. Kaslow, Florence Whiteman; Marvin B. Sussman. "Cults and the Family". Haworth Press. 1982. p. 34.
23. Larson, Bob. "Larson's New Book of Cults". Wheaton, Illinois, Tyndale House. 1982, p.14
24. Lewis, James R. The Oxford Handbook of New Religious Movements. Oxford University Press US. 2004
25. Martin, Walter R. "The Kingdom of the Cults". Bethany Fellowship Inc., Publishers, Minneapolis, Minnesota. 1985
26. MacKenzie, U. and Morrison, B. "New Religious Movements in Britain Today: A Resource Paper from CYFA". London, Church Youth Fellowships Association, 1982
27. McDowell, Josh and Stewart, Don "The Deceivers: What Cults Believe; How They Lure Followers". Amersham, Scripture Press., 1992
28. Melton, J. Gordon., "The Rise of the Study of New Religions". CESNUR 99. http://www.cesnur.org/testi/bryn/br_melton.htm. (1999) ЭШЛЭСЭН 2017.01.20
29. Melton, J Gordon and Moore, Robert L. "The Cult Experience: Responding to the New Religious Pluralism". New York, The Pilgrim Press.1982;
30. Miller, Timothy. "America's alternative religions". State University of New York. 1995
31. Nelson, Geoffrey K. "Cults, New Religions and Religious Creativity". London, Routledge and Kegan Paul. 1987
32. Robinson, B.A."Doomsday, destructive religious cults". Ontario Consultants on Religious Tolerance, 2007
33. Richardson, James T. "Definitions of Cult: From Sociological-Technical to Popular-Negative". Review of Religious Research. 1993
34. Richardson, James T.; Introvigne, Massimo. "Brainwashing' Theories in European Parliamentary and Administrative Reports on 'Cults' and 'Sects'". Journal for the Scientific Study of Religion. 2001. pp. 143–168
35. Saliba, John S.J. "Understanding new religious movements" second edition, Altamira press, 2003, pages 140-141, дам ишлэв.
36. Stark, Rodney; Bainbridge, William Sims. "The Future of Religion: Secularization, Revival and Cult Formation". Berkeley, CA: University of California Press. 1987
37. Stark, Rodney; Bainbridge, William. "A Theory of Religion". Peter Lang Publishing. 1996. p. 155
38. Singer, Margaret Thaler. "Coming out of the Cults" in Psychology Today. 1979. Resource: <http://www.cultfaq.org/coming-out-of-the-cults.html>
39. The Oxford Handbook of New Religious Movements, Oxford University Press, 2008, p.17
40. Troeltsch, Ernst. "The Social Teachings of the Christian Church", London, Macmillan, 1931
41. Turner, Francis J.; Arnold Shanon Bloch, Ron Shor. "Differential Diagnosis & Treatment in Social Work" (4th ed.). Free Press. 1995. pp. 1146: Chapter 105: "From Consultation to Therapy in Group Work with Parents of Cultists"
42. Yinger, J. Milton. "The Scientific Study of Religion", London, 1970
43. van Driel, Barend; J. Richardson. "Cult versus sect: Categorization of new religions in American print media". Sociological Analysis. 49 (2), 1988, pp. 171–183
44. Wright, Stewart A. "Media Coverage of Unconventional Religion: Any 'Good News' for Minority Faiths?". Review of Religious Research, Vol. 39, No. 2. 39 (2), 1997, pp. 101–115